



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/131

Мандалговь

Байгууллагын чанарын бодлого, зорилт  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартын 5.1.1 дэх заалт үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/40 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний 18 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын “Чанарын бодлого, зорилт”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Байгууллагын чанарын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллагын болон төрийн албан хаагчдын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Чанарын зорилтын хэрэгжилтийг жил бүр тооцон гаргаж, Чанарын удирдлагын хороонд жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор танилцуулж байхыг Чанарын менежер (Э.Одончимэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

Дундговь аймгийн ЗДТГ-ын Даргын  
 2019 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн  
 №1131 дугаар тушаалын хавсралт



Дундговь аймгийн Чанарын удирдлагын тогтолцооны чанарын бодлого

Мэргэшсэн, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн төрийн үйлчилгээг тасралтгүй сайжруулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээдэлсэн байгууллага болно.

ЗОГСЛОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА МАНЛАЙЛЪЯ

Чанарын зорилт

| № | Чанарын зорилт  | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэмжих шалгуур үзүүлэлт   | Хүрэх түвшин                    | Хариуцах нэгж | Хугацаа    |
|---|---|--|---|---------------------------------|---------------|------------|
| 1 | 2019-2020 онд албан хаагчдын 50-аас дээш хувийг багц сургалтад хамруулах, богино хугацааны сургалтад 80-аас дээш хувийг хамруулах | 1. Шаталсан болон кредитийн сургалтад хамруулах<br>2. Хүний нөөцийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах<br>3. Ёс зүй, харилцааны соёлын сургалтад хамруулах<br>4. Богино хугацааны сургалтад хамруулах | - Хамрагдах сургалтын кредит цагийн тоо<br>- Хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэх<br>- Зохион байгуулах сургалтын тоо<br>- Хамрагдах албан хаагчийн хувь | 2<br><br>80<br><br>2<br><br>100 | ТЗУХ          | 2019 -2020 |
| 2 | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн хяналтын үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх                                     | 1. ИНБ, ТББ-ын оролцоог хангах<br>2. Иргэдтэй уулзах уулзалтаар иргэдийг сонсох, судалгаа авах   | Уулзалтын тоогоор   | 4                               | ХОХБТХ, НБХ   | 2019-2020  |
| 3 | Иргэдийн сэтгэл ханамжийг жил тутам 2 хувиар нэмэгдүүлэх  | 1. Жил бүр сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тооцох<br>2. Салбарын хэмжээнд хэрэглэгчийн үнэлгээ хийх  | - Сэтгэл ханамжийн судалгааны хэрэглэгчийн хувиар<br>- Эрсдлийн үнэлгээ хийх  | 56 хувиас дээш<br><br>2         | ХШУДАХ        | 2019-2020  |

|   |  |  | тоо  |            |                 |           |
|---|--|--|--|------------|-----------------|-----------|
| 4 | Ил тод байдлын үзүүлэлтийг 87.1 хувиас жил бүр 3 хувиар нэмэгдүүлнэ. | 1. Төсөв санхүүгийн ил тод байдлын мэдээллийг сайтад тогтмол мэдээлэх<br>2. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх | - Сар бүр мэдээлэх тоо<br><br>- Улиралд мэдээлэх тоо | 1<br><br>2 | СТСХ,<br>ХОХБТХ | 2019-2020 |

Аймгийн Засаг даргын Тамгын газар